



# МОНГОЛЫН ЦАХИМ ХУДАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛЬ

Жонн Д Григорий / Анбатын Дэлгэрмаа

2023 оны 1 дүгээр сар

# ЦАХИМ ХУДАЛДАА ГЭЖ ЮУ ВЭ?

## Дэлхийн худалдааны байгууллага (WTO)-ын тодорхойлолт

Цахим худалдаа буюу цахим арилжаа нь "цахим хэрэгслээр бараа, үйлчилгээг үйлдвэрлэх, түгээх, зах зээлд гаргах, борлуулах, хүргэх" ажлыг хэлнэ гэж тодорхойлдог (1998).

Цахим худалдааны гүйлгээ нь аж ахуйн нэгж, өрх, хувь хүмүүс, төрийн болон олон нийтийн, хувийн байгууллагуудын хооронд байж болно.

Дэлхийн худалдааны байгууллага :

[https://www.wto.org/english/thewto\\_e/minist\\_e/mc11\\_e/briefing\\_notes\\_e/bfecom\\_e.htm](https://www.wto.org/english/thewto_e/minist_e/mc11_e/briefing_notes_e/bfecom_e.htm)

# АРИЛЖАА, ЦАХИМ ХУДАЛДАА

Trade (худалдаа, наймаа) нь илүүтэй гүйлгээнд төвлөрдөг; commerce (худалдаа, арилжаа) нь илүү өргөн хүрээний эдийн засгийн үйл ажиллагаанд төвлөрдөг гэж хэлж болно.

Commerce нь худалдааг хөнгөвчлөхөд шаардлагатай бүх ажиллагааг багтаадаг, өөрөөр хэлбэл бараа, үйлчилгээг үйлдвэрлэгчээс хэрэглэгчдэд хүргэх ажиллагааг гэсэн үг. Энэ бүх явцыг амжилттай дуусгахын тулд тээвэрлэлтийг зохион байгуулах, банк, даатгалын үйлчилгээ үзүүлэх, бүтээгдэхүүнийг сурталчлах, зах зээлд гаргах, агуулахад хадгалах зэрэг ажиллагаа орно.

Үүний үр дүнд "цахим худалдаа" гэдэгт дан ганц "наймаа" буюу түүнд шууд хамааралтай байхаас үл хамааран цахим харилцаа холбооны хэрэгслээр хийж буй дээрх бүх ажиллагааг ойлгох хандлагатай байдаг.

# МОНГОЛ ДАХЬ ЦАХИМ ГҮЙЛГЭЭ

Дээрх ажиллагааг цахимаар хийхэд хууль тогтоомжийн нэмэлт, өөрчлөлт, зохицуулалт шаардлагагүй байж болно. “Худалдааг дэмжих арга хэмжээ”-г цахим гүйлгээ, цахим гарын үсгийг ашиглан цахим хэлбэрээр явуулж болохыг Монгол Улсын одоо мөрдөж байгаа Иргэний хууль болон Цахим гарын үсгийн тухай хуулиар зөвшөөрсөн байдаг.

- ***Монгол улсын Иргэний хууль***, 42<sup>1</sup>.1-р зүйл, 43.2.4-р зүйл, 196.1.8-р зүйл
- ***Цахим гарын үсгийн тухай хууль***, 2021.

Товчхон тайлбарлахад, хэрэв бичгээр хийх гүйлгээнд дээрх хуулийн дагуу цахим гарын үсэг зурсан бол, хэрэв нотариатаар баталгаажуулсан байхыг шаардсан бол ийнхүү баталгаажуулсан бол, энэ гүйлгээ цахим хэлбэрээр байж болно.

- ***Нотариатын тухай хуулиар нотариат цахимаар гарын үсэг зурахыг мөн зөвшөөрсөн байдаг.***

# ЦАХИМ ГАРЫН ҮСЭГ(1)

- Баримт бичигт цахим гарын үсэг зурах олон арга бий. Цахим гарын үсгийн тухай хуульд (2021 онд баталж, 2022 оны 5-р сард хүчин төгөлдөр болсон) цахим мэдээлэлд гарын үсэг зурсан, цахим тамга хэрэглэсэн этгээдийг тодорхойлох зорилгоор мэдээлэлд хавсаргасан, эсхүл нэгтгэсэн цахим өгөгдлийг цахим гарын үсэг гэж тодорхойлсон байдаг.
- Монгол Улсын нэгдэн орсон НҮБ-ын “Цахим харилцааны конвенц”-ид "талыг таних, цахим харилцаанд агуулагдаж буй мэдээллийн талаар тухайн талын хандлагыг илэрхийлэх ...аргыг" ашиглах тухай заасан (хандлага буюу зорилгыг гарын үсгийн хэлбэрээс бус, түүний агуулгаар тогтоодог)
- Цахим гарын үсгийн тухай хуульд цахим гарын үсэгт онцой эрх өгч хуульчлаагүй, харин Иргэний хуульд онцлон заасан байдаг.
- Цахим гарын үсгийн тухай хуульд тоон гарын үсэг нь гараар бичсэн гарын үсэгтэй адил хүчин төгөлдөр гэж заасан.

## ЦАХИМ ГАРЫН ҮСЭГ (2)

- Гарын үсэг зурах технологи болон Монгол Улсын хууль тогтоомжид "цахим гарын үсэг" болон "тоон гарын үсэг"-ийг хоёуланг нь хүлээн зөвшөөрдөг.

Тоон гарын үсэг гэдэг нь гэрчилгээжүүлэлтийн төвөөс тухайн түлхүүрийг ашиглах эрх бүхий этгээдийг тодорхойлсон гэрчилгээний хамт ашигладаг шифрлэлтийн түлхүүрийг ашиглан үүсгэсэн цахим гарын үсгийн ангилал юм. Гарын үсэг зурсан баримт бичгийг хүлээн авагч нь гарын үсэг зурснаас хойш тухайн текст өөрчлөгдсөн эсэхийг мэдэх боломжтой.

- Монголын холбогдох хууль тогтоомж, ялангуяа тэдгээрийн орчуулгад цахим гарын үсэг эсвэл тухайлан тоон гарын үсэг хоёрыг тодорхой ялгахгүйгээр ашиглах талтай байна.
- Тоон гарын үсэг бий болгодог системийг удирдахад хэцүү байх талтай. Олон төрлийн хувийн гүйлгээнд ийм өндөр хамгаалалт бүхий гарын үсэг шаардлагагүй.
- Түүгээр ч барахгүй хууль хүчин төгөлдөр болоод 6 сар өнгөрөөд байхад гэрчилгээний систем, гэрчилгээний төвүүд (эдгээр нь хүчингүй болсон гэрчилгээний жагсаалтыг хянах үүрэгтэй) үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй л байна. Үүнээс болж хувийн гүйлгээг цахим хэлбэрээр хийх нь ховор, гэхдээ худалдааны платформ дээр хувийн гүйлгээг цахим хэлбэрээр хийж байгаа.

## ЦАХИМ ГАРЫН ҮСЭГ (3)

- Олон улс, тэр дундаа Азийн орнууд цахим гарын үсгийн тоон болон тоон бус гарын үсэг зэрэгцэн орших ийм төрлийн “эрлийз”, “хосолсон” цахим гарын үсгийн системийг олон өөр зорилгоор ашигладаг.
  - Ийм зорилгын нэг бол төрийн байгууллагуудтай харилцах, өндөр үнэ цэнтэй гэрээ байгуулах явдал юм.
  - Арилжааны гүйлгээнд оролцогч талууд гарын үсэг зурах ямар технологийг ашиглах вэ гэдгийг өөрсдөө чөлөөтэй шийдэх эрх мэдэлтэй.
- “Цахим Монгол” (E-Mongolia) хөтөлбөр нь төрийн үйлчилгээг орон даяар цахим хэлбэрээр явуулж байна. Одоогийн байдлаар улсын болон орон нутгийн хэмжээнд 2000 орчим үйлчилгээг цахимаар санал болгож байна.
  - Хөтөлбөрийн хүрээнд төрийн байгууллагатай харьцдаг иргэд ихэвчлэн тоон гарын үсгийг ашигладаг.
- Монгол улсын төрийн байгууллагууд хувийн хэвшлийн зарим төрлийн хэрэглээнд загвар болохуйц хэд хэдэн баталгаажуулалтын өөр аргыг ашиглаж байна.
  - Худалдан авах боломжтой арилжааны цахим гарын үсгийн систем бас байдаг

# ЦАХИМ ХУДАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ТУСГАЖ БОЛОХ БУСАД АСУУДАЛ (1)

- “Цахим гүйлгээ”, “цахим гарын үсэг”-ээс гадна “цахим худалдааны” хуулийн олон улсын загваруудад бусад асуудлыг мөн тусгасан байдаг.
- Жишээлбэл, UNCITRAL-ийн Цахим худалдаа, цахим гарын үсгийн тухай загвар хуулиуд (мөн Цахим харилцааны конвенц) нь дараахь асуудлаар тодорхой дүрэм заасан байдаг.
  - Ижил тэгш хандах, ялгаварлахгүй байх (хууль нь цаасан дээрх ба цахим хэлбэрийн өгөгдлийг адилхан авч үзэх зарчим)
  - Цахим нотлох баримт
  - Бичлэг хадгалах
  - Илгээх, хүргэх хугацаа
  - Хүний оролцоогүй гэрээ
  - Компьютертэй харьцах үед гарсан алдааг засах



# ЦАХИМ ХУДАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ТУСГАЖ БОЛОХ БУСАД АСУУДАЛ (2)

- Түүнчлэн Монголын оролцогч талуудын (төрийн болон хувийн хэвшлийнхэн) уулзалтын үеэр цахим худалдааны талаар нийтээр дагаж мөрдөх хуулиар зохицуулах бусад асуудлыг санал болгов.
  - Бизнесийн байгууллагуудын дундах шударга байдал
    - тэнцүү ашиг тус, тэгш ачаалал, жишээ нь: татвар, хураамжийн хувьд
  - Кибер гэмт хэргээс хамгаалах
  - Тусгай бүтээгдэхүүний стандарт, жишээ нь: эрүүл мэндийн салбарт ашиглах зүйлийг цахим орчинд борлуулах
  - Зарим практик асуудал
    - хил, гаалийн журам
    - хүргэлтийн асуудал (“хаягжуулалт”)
    - мэдээллийн нууцлал
    - цахим төлбөрийн илүү сайн систем зэрэг.

# ОЛОН УЛСЫН АСУУДАЛ

Олон улсын хувьд- Монгол Улсын нэгдэн орсон, эсвэл нэгдэн орж болох конвенц, гэрээ хэлэлцээр нь хэд хэдэн шалтгааны улмаас сонирхол татаж байна:

- Конвенцийн хамрах хүрээнээс хамааран тухайн хэлэлцээрт цахим харилцаа холбоог зохицуулсан байгааг нь Монгол Улсад одоо хэрэглэж болох юм, энэ нь Иргэний хууль, эсвэл Цахим гарын үсгийн тухай хуулиас өөр бусад эрх зүйн эх сурвалж болно.
  - Үүний тод жишээ бол НҮБ-ын Цахим харилцааны конвенц юм.
- Монголын ирээдүйн хуулиудыг боловсруулахад дэмтэй байж болно. Учир нь тэдгээрт олон оновчтой санаа буй, мөн олон улсын худалдаа эрхлэгч зарим монголчуудад танил болсон байж болно.
- ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээр гэх мэт худалдааны гэрээнүүд болон олон улсын бусад хууль тогтоомж нь дотоодын гүйлгээний аргачлал, эсвэл ирээдүйн сонголтыг боловсронгуй болгоход нөлөө үзүүлж болно.
  - Энэхүү төслийн бүрэн тайланд үүнтэй холбоотой асуудлууд болон олон улсын гэрээ хэлэлцээрийн талаар илүү дэлгэрэнгүй авч үзсэн болно.

# ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ХҮРЭЭ

1. ЦАХИМ ХУДАЛДААНЫ НИЙТЛЭГ ХУУЛЬ БАТЛАХ, ҮНДСЭНДЭЭ БОЛ НҮБ-ЫН ЦАХИМ ХАРИЛЦААНЫ КОНВЕНЦИЙГ ГЭСЭН ҮГ.
2. БҮРТГЭЛ, ТАТВАРЫН ЗОРИЛГООР “ЦАХИМ БИЗНЕС” ГЭЖ ЮУ БОЛОХЫГ ТОДОРХОЙЛОХ.
3. ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН “ХОСОЛСОН” ДЭГЛЭМИЙГ ТОГТООХ, ҮҮНД ТООН ГАРЫН ҮСГИЙГ ӨНДӨР ҮНЭ ЦЭНТЭЙ ГҮЙЛГЭЭНД, ЭСВЭЛ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАД АШИГЛАХ ЗОРИЛГОТойгоор ТОГТООХ.
4. БУСАД ЗУУЧЛАГЧДЫН АДИЛ АРИЛЖААНЫ ПЛАТФОРМЫН АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ.
5. ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ШИНЭ ХУУЛИЙГ ДЭМЖИЖ, ХЭРЭГЖИЛТИЙГ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ.
6. НУУЦЛАЛЫН ШИНЭ ХУУЛИЙГ ДЭМЖИХ, ХИЛ ДАМНАСАН ХЭСГҮҮДИЙГ НЬ ИЛҮҮТЭЙ АНХААРАХ.
7. ЦАХИМ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ ШИНЭ АРГА ХЭРЭГСЛҮҮДИЙГ НЭВТРҮҮЛЭХ, ГЭХДЭЭ ЦАГДААГИЙН ХЭТ ОРОЛЦОХООС СЭРЭМЖЛЭХ.

# НЭГ ДЭХ АСУУДАЛ: МОНГОЛД ЦАХИМ ХУДАЛДААНЫ ТУХАЙ ХУУЛЬ БАЙХ ХЭРЭГТЭЙ ЮУ?

Нааштай нь:

- "Цахим бизнес" гэж юу болохыг тодорхойлоход тустай.
- Цахим гүйлгээний гарын үсгийн хэлбэр гэхээс илүүтэй цахим гүйлгээний хүчинтэй байдалд анхаарах болно (одоо ганц дүрэм нь энэ байгаа)
- Дотоодын болон хил дамнасан харилцааны зохицуулалтыг харилцан уялдуулж болох юм.

Эсрэг нь:

- Одоо цахим гүйлгээг Иргэний хуулиар зохицуулж байгаа тул шаардлагагүй
- "Цахим бизнес"-ийн тодорхойлолт нь зорилгоосоо шалтгаалан маш олон янз байна

**ЗӨВЛӨМЖ:** НҮБ-ын Цахим харилцааны конвенцийг зорилгодоо нийцүүлэх.

**ЗӨВЛӨМЖ:** Цахим худалдааг зохицуулдаг тусгай “агентлаг”, “байгууллага” байх шаардлагагүй.

# ХОЁР ДАХЬ АСУУДАЛ: ХУУЛЬД “ЦАХИМ БИЗНЕС”-ИЙГ ТОДОРХОЙЛОХ ХЭРЭГТЭЙ ЮУ?

Нааштай нь :

- Цахим худалдаанд оролцогчдын эрх, үүргийг илүү тодорхой хуваарилах боломжтой болно.
- Худалдааны практикт илүү сайн статистик дүн шинжилгээ хийх боломж бүрдэнэ.
- Цахим худалдаанд татаас, эсвэл урамшууллыг илүү сайн хуваарилах боломжтой.
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг шинэчлэх төсөлд “бизнес эрхлэгч”, “цахим бизнес эрхлэгч” гэж тодорхойлсон.

Эсрэг нь:

- Цахим харилцааг ашигладаг аливаа бизнес бол цахим бизнес юм, ангилж салбарчлах нь хийсвэр юм.
- Хэт хатуу, уян бус тодорхойлолт, ангилал нь инновацид саад болж болзошгүй.

Ямар ч тохиолдолд татварын болон урамшууллын бодлоготой уялдуулах шаардлагатай.

# ГУРАВ ДАХЬ АСУУДАЛ: ЦАХИМ БИЗНЕСИЙГ АНГИЛАХ НЬ

Хувилбарууд:

- Бизнесийн хэмжээ, жилийн орлого, жилийн ашиг, ажиллагсдын тоогоор ангилах уу?
  - Ингэх нь зарим бизнест чиглэсэн оновчтой бодлого явуулах боломжтой болгох уу?
- Бизнесийн хэлбэр: корпораци, нөхөрлөл, хуульд заасан бусад нэгж?
  - Тогтвортой, тууштай ажиллах нотолгоо байж болно.
- Бодит байршилтай эсэх, онлайн ажилладаг эсэх, онлайнгаар эсвэл бодитоор хийсэн бизнесийн харьцаа
- Хэрэглэгчээр нь ангилах, тухайлбал, хэрэглэгчид, бусад бизнес эрхлэгчид, хувийн, эсвэл төрийн хэвшил, импорт, экспорт эрхэлдэг, эсвэл зөвхөн дотооддоо гэх мэт.
- Борлуулж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр
- Бизнесийг онлайн хийх арга хэрэгслээр: өөрийн вэбсайт, худалдааны платформ, социал сүлжээ
- “Цахим бизнес” гэж өөрийгөө тодорхойлдог байх уу, сайн дураараа бүртгүүлдэг? (ингэх нь урамшуулалтай байх уу?)

# ДӨРӨВ ДЭХ АСУУДАЛ: ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ИЛҮҮ УЯН ХАТАН БОЛГОХ УУ?

Нааштай нь:

- Цахим гарын үсгийн аюулгүй байдал ямар байх талаар заалт хуульд байхгүй (тоон гарын гарын үсгийн аюулгүй байдал үүнд хамаарахгүй), бүгд ижил.
- Олон гүйлгээнд гэрчилгээгээр баталгаажсан бүрэн тоон гарын үсгийн хамгаалалт хэрэггүй [Интернетийн инженерчлэлийн ажлын хэсэг (IETF)-ийн стандартууд]
- Төрийн байгууллагын хамгаалалтыг ихэвчлэн бүрэн тоон гарын үсгээс өөр аргаар үүсгэж болно. Хувийн талуудад ч ийм боломж байх ёстой.
- PKI итгэлцлийн үйлчилгээнд үзүүлэх дэмжлэг нь олон гүйлгээнд шаардагдахаас илүү үнэтэй байдаг.

Эсрэг нь:

- Монгол Улсад тоон гарын үсгийг эзэмших, ашиглахад харьцангуй хялбар байдаг учраас бусдад зөвшөөрөх шаардлагагүй [гэвч одоо зөвхөн төрийн албанд зөвшөөрч буй]

**ЗӨВЛӨМЖ:** НҮБ-ын Цахим харилцаа холбооны конвенцид үндэслэсэн уян хатан дүрэмтэй болох, ялангуяа хувийн хэвшилд зориулж.

**ТАЙЛБАР:** Дүрэм нь гарын үсэг зурж буй зүйлээс хамаарна: баримт бичгийн шинж чанар, талууд, үнэ цэн, нийтийн ашиг сонирхол зэрэг (Сингапур, Хонг Конг гэх мэт олон жишээ байна)

# ТАВ ДАХЬ АСУУДАЛ: ХУДАЛДААНЫ ПЛАТФОРМЫГ ХУУЛИАР ЗОХИЦУУЛАХ ХЭРЭГТЭЙ ЮУ?

[Энэ асуудал нь зуучлагчдын үйл ажиллагааг зохицуулсан журмын хэсэг байж болно.]

Худалдааны платформуудын чиг үүрэг:

- Бараа, үйлчилгээг шударгаар үзүүлэх
- Платформын хэрэглэгчидтэй шударга бусаар өрсөлдөхгүй
- Хэрэглэгчийн зарим хамгаалалт байх, өөрөөр хэлбэл платформ нь хэрэглэгчдийг платформ хэрэглэгчдийн алдаанаас хамгаалах
- Хувийн нууцлалын зарим хамгаалалт байх, өөрөөр хэлбэл, платформ нь бизнесийн мэдээллийг өөртөө давуу тал болгон ашиглахгүй (худалдаа, борлуулалтад зэрэг)

**ЗӨВЛӨМЖ:** Тиймээ. Гэхдээ гадаадад суурилсан нэр хүндтэй платформуудад энэ нь хамаарах ёстой: шууд журам, хэрэглэгчдэд зориулсан сэрэмжлүүлэг.

Вьетнам, Лаос, БНХАУ-ын гадаадын платформын тухай хуулийг авч үзэж болно

Мөн олон улсад хамгийн бага оролцоо, зохицуулалтыг илүүд үздэг



# ЗУРГАА ДАХЬ АСУУДАЛ: ХЭРЭГЛЭГЧИЙН ХАМГААЛАЛЫН ШИНЭЧЛЭЛ

- Цахим худалдааг ашиглахдаа аюулгүй харилцаж, захиалсан зүйлээ хүлээн авах, эсвэл аваагүй бол арга хэмжээ авах боломжтой гэсэн хэрэглэгчдийн итгэлээс цахим худалдааны ашиглалт хамаарна.
- Гомдлыг барагдуулах боломж, баталгаатай байх нь бодит дүрэм, журмаас илүү чухал байж болно.
  - Төрийн байгууллага ихэвчлэн энэ асуудлыг хариуцдаг. Асуудлыг хариуцсан Монголын төрийн байгууллагын боломж нөөц хомс.
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг шинэчлэх төсөл бэлтгэгдэж буй.
- Зар сурталчилгааны тухай хуулийн зохицуулалт бүх худалдаа эрхлэгчдийг шударгаар хамарч байгаа эсэхийг нь авч үзэх

**ЗӨВЛӨМЖ:** төрийн аль нэг байгууллага (ЦХХХЯ биш) дээр бэлтгэж буй шинэ хуулийг батлахад дэмжлэг үзүүлэх; оновчтой үр дүнтэй хэрэгжүүлэх механизм (болон нөөц)-г бий болгох.

# ДОЛОО ДАХЬ АСУУДАЛ: НУУЦЛАЛ

- 2021 онд баталж, 2022 онд хүчин төгөлдөр болсон Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль нь хангалттай сайн зохицуулалттай болсон байна. Энэ хуулийн үндсэн хэсэгт өөрчлөлт оруулах талаар аливаа санал гаргахад эрт байна.
- Хууль тогтоомжийг чанд нямбай хэрэгжүүлэх нь чухал. Хүний эрхийн үндэсний комисс нь хуулиар олгосон эрх, үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, захиргааны чадавхтай байх ёстой (мөрдөх ажиллагаа - гомдолд хариу өгөх - захирамж гаргаж, гүйцэтгүүлэх)
- Дээрх хуулийн дагуу хүлээн авах улстай хуульд нийцсэн гэрээ байгуулсан тохиолдолд хувийн мэдээллийг хилээр дамжуулахыг зөвшөөрдөг. Мэдээллийг хүлээн авсан улс нь хувийн мэдээллийг хамгаалах талаар Монгол Улсынхтай дүйцэхүйц нөхцөлийг хуульдаа тусгасан байх ёстой.

# ДОЛОО ДАХЬ АСУУДАЛ: НУУЦЛАЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Монголд буй этгээдтэй холбоотой хувийн (эсвэл бизнесийн) мэдээллийг зөвхөн Монголдоо боловсруулж, хадгалах ёстой гэсэн саналуудыг өмнө нь гаргаж байжээ.
- Энэхүү "өгөгдлийг нутагшуулах" бодлого нь хил дамнасан аж ахуйн нэгжүүдэд үр ашиггүй юм: ийм дүрэмтэй улс орон тус бүрт мэдээлэл боловсруулж хадгалах байгууламжийг тусад нь бий болгох шаардлагатай болно гэсэн үг.
  - Монгол-Японы худалдааны хэлэлцээрээр болон чөлөөт худалдааны хэд хэдэн хэлэлцээрт ийм бодлого явуулахыг хориглосон байдаг (гэхдээ өгөгдлийг нутагшуулах зарчмаас давамгайл төрийн бодлогын шалтгаан байж болно, энэ нь ховор боловч төсөөлж хэрэгжүүлэхүйц юм)  
Монгол-Японы худалдааны хэлэлцээр, 9.10-р зүйл
- **ЗӨВЛӨМЖ:** Монгол Улсад мэдээллийг нутагшуулах бодлого баримтлахыг зөвлөхгүй. Гадаад шилжүүлэгтэй ижил хэмжээний хамгаалалт тогтоох нь хангалттай бөгөөд сайн.

# НАЙМ ДАХЬ АСУУДАЛ: КИБЕР ГЭМТ ХЭРЭГ

---

- Эрүүгийн хуульд компьютерийг зүй бусаар ашиглах, хортой программ үүсгэх гэм мэт гэмт хэргийн тухай зохицуулалтууд нь хангалттай сайн тусгагдсан байна.
  - Хэрэв Монгол Улс нь Кибер гэмт хэргийн эсрэг Будапештийн конвенцид нэгдэхийг хүсвэл цахимаар үйлдэж болох гэмт хэргүүдийн талаарх зүйл заалтуудаа авч үзэх шаардлагатай болж магадгүй.
- Саяхан баталсан Кибер аюулгүй байдлын тухай хууль нь кибер гэмт хэрэгтэй хил дамнан үр дүнтэй тэмцэхэд төрийн холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхийг шаардах магадлалтай.

# НАЙМ ДАХЬ АСУУДАЛ: КИБЕР ГЭМТ ХЭРЭГ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Цагдаагийн байгууллагаас гэмт хэрэг үйлдсэн байх сэжигтэй үед банкны шилжүүлгийг хянан шалгах эрхээ нэмэгдүүлэх хүсэлт гаргажээ.

**ЗӨВЛӨМЖ:** бүх талуудын эрхийг хамгаалах үүднээс энэ асуудал дээр маш болгоомжтой байх хэрэгтэй.

**ЗӨВЛӨМЖ:** залиланд зүй бусаар өртсөн хүнд шилжүүлгийг зогсоосноос болж хохирол учирсан бол залилангийн гэмт хэргийн эсрэг арга хэмжээ авч буй этгээд нь хохирлыг нь барагдуулах шаардлагатай байж магадгүй юм.

Прокурор, мөрдөн байцаагч, санхүүгийн байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлснээр хуулийн шинэчлэл хийх шаардлагагүй болно.

# ОЛОН УЛСЫН АСУУДЛААРХ САНАЛ

- НҮБ-ын Цахим харилцааны конвенцийг Монгол Улсын дотоодын цахим худалдааны хууль болгон хэрэглэх, өмнө нь ярьсан зарим нэмэлт заалт оруулна.
  - Энэ конвенцийг бусад гэрээ хэлэлцээрийг тайлбарлахад ашиглаж болдог
- Хил дамнасан цахим худалдааны тусгай эрх зүйн орчин:
  - Дотоодын хууль нь ихэвчлэн хил дамнасан гүйлгээний харилцааг зохицуулдаг, гэхдээ орон болгонд биш
  - Татвар, тарифаас чөлөөлөх “de minimis” босго:
    - Босго болох үнэлгээг тогтоох
    - Одоогийн байдлаар зөвхөн шуудангийн илгээмжид хамаарч байгаа шиг биш
  - Дэлхийн гаалийн байгууллагын хил дамнасан цахим худалдааны стандартууд
  - Цахим худалдааг зохицуулсан ерөнхий дүрэм тогтоож хэрэгжүүлэх нь хэцүү байж болно, Хятад, Вьетнамын жишээ
  - Биет бус хөрөнгийн худалдаа – шинэ асуудлууд – биет бус үнэт зүйлс хил дээр зогсдоггүй тул түүнийг хил дамнаж шилжүүлэх үнэ цэнийн талаарх ДГБ/ЭЗХАХБ-ын дүрэм журам.
  - Гадаадаас ирж буй цахим төлбөрийн дүрмийг сайжруулах шаардлагатай байна
    - Жишээ нь: PayPal, бусад цахим төлбөрийн аргууд

## ОЛОН УЛСЫН АСУУДЛААРХ САНАЛ (2)

- Ази - Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссийн Ази, Номхон далайн Хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай суурь хэлэлцээрийн хүрээнд АНДЭЗНК-ын ажлын хэсгүүд, ялангуяа техникийн болон хууль эрх зүйн бүлгүүдэд оролцож ажиллах.
- Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэлд (RCEP) нэгдэх талаар судалж, түүний цахим худалдааны заалтуудыг анхаарч үзэх.
- Санхүү, худалдааны салбараас хангалттай эрэлт хэрэгцээтэй байгаа үед НҮБ-ын UNCITRAL-ийн Цахимаар шилжүүлэх боломжтой мэдээллийн тухай загвар хуулийг хэрэгжүүлэх асуудлыг авч үзэх.
- Экспорт, импортын баримт бичгийн дотоодын нэгдсэн цонхыг боловсруулахдаа ISO болон НҮБ-ын Худалдааг хөнгөвчлөх, цахим бизнесийн төв (CEFACT)-н стандартуудыг харгалзах.

# ЦААШДЫН АЖИЛ

- Зайнаас нотариатаар гэрчлүүлэх: Нотариатын тухай хуулиар нотариат нь цахим нотариатаар гэрчлүүлсэн баримт бичгийг бий болгохыг зөвшөөрдөг боловч зөвхөн биеэрээ очиж ийнхүү нотариатлуулна (гэж ойлгосон). Гарын үсэг зурсан хүмүүс болон нотариат нь нэг газар хамт байхгүй тохиолдолд нотариатаар гэрчлэх боломжтой болгох, энэ нь гүйлгээг илүү үр дүнтэй хийх боломжтой болгоно.
- Маргаан шийдвэрлэх: Монгол Улс арбитрын тухай олон улсын үндсэн баримт бичгүүдэд нэгдэн орсон. НҮБ-ын Эвлэрүүлэн зуучлалын тохиролцоог хэрэгжүүлэх тухай конвенц (UN Convention on the Enforcement of Settlements in Mediations)-д нэгдэх нь зүйтэй.
- Иргэний хариуцлага: Харилцаа холбооны зуучлагчийн хариуцлагыг үйлчлүүлэгчидтэй байгуулсан гэрээгээр хязгаарлахын зэрэгцээгээр дамжуулсан зүйлийнх нь улмаас учруулсан хохирлын хариуцлагыг хуулиар тодорхой болгох (үүнд, худалдааны платформ нь онцгой тохиолдол байж болно.)
- Энэ чиглэлээрх хуулийн шинэчлэлд Манилагийн зарчмуудыг удирдамж болгон ашиглах.



# АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Эдгээр зөвлөмжүүдийг ЦХХХЯ (болон АХБ)-аас хүлээн авах
- Эцсийн тайланг бэлтгэх, түүнд нэмэлт, залруулга хийх, энэхүү хэлэлцүүлгээс гарсан зөвлөмж болон хуулийн заалтуудын төслийг боловсруулах зааврыг тусгах (үүнд Хууль тогтоомжийн тухай хуулийн шаардлагыг харгалзан үзэх) ("5 дугаар үе шат")